

МОНГОЛЫН СОНГОГЧДЫН УЛС ТӨРИЙН ТАЛААРХ МЭДЛЭГ БОЛОВСРОЛ

Ж.Төртогтох

доктор, дэд профессор
(МУИС, Улс төр судлалын тэнхим)

Оршил

Энэхүү өгүүлэл нь МУИС-ийн Азийн Судалгааны Төвийн (АСТ) санхүүжилтээр, Орчин үеийн улс төрийн судалгааны төвөөс эрхлэн гүйцэтгэсэн “Монгол дахь сонгогчдын боловсрол” төслийн судалгааны үр дүн, агуулгад тулгуурлан бичигдсэн болно. Уг төслийн судалгааны гол дүгнэлт нь төслийн хүрээнд хийгдсэн 1/ нийт 800 түүвэр бүхий анкетын тоон судалгаа; 2/ 200 түүвэр бүхий тандалт судалгааны дүгнэлтүүдэд үндэслэгдэж байгаа болно.

Судалгааны үр дүнг хэсэгчилсэн байдлаар урьд өмнө хэд хэдэн удаагийн олон улсын бага хурлаар хэлэлцүүлж байсан болно¹. Энэхүү өгүүллээр төслийн үр дүнг нийтэд нь хураангуйлан нэгтгэж танилцуулахыг зорьлоо.

Судалгааны үндсэн зорилго нь Монгол дахь сонгогчдын боловсролын өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ өгөх, цаашид сонгогчдын улс төрийн боловсролыг сайжруулах арга хэрэгслийг боловсруулахад саналаа нэмэрлэх явдал юм. Энэ үүднээс сонгогчдын боловсролыг иргэний болон улс төрийн чиглэлээр ялган үзэж, энэ талаарх олон нийтийн санаа бодлыг судлах, анализ хийх зорилт тавьж ажиллалаа. Ингэснээр ардчилсан сонгуульд суралцаж буй манай орны иргэдийн хувьд улс төрийн боловсрол, мэдлэгийн түвшин ямар байгаад ерөнхий үнэлгээ өгөх бололцоо олгох ач холбогдолтой юм.

Сонгогчдын улс төрийн талаарх мэдлэг, ойлголт, боловсрол

Судалгааны түүврийн хэмжээ, цар хүрээг тооцохдоо Монгол орны нийт нутаг дэвсгэрийг төлөөлөхүйц бүс нутаг тус бүрээс нэг аймгийг сонгон авсан. Тухайлбал, баруун бүсээс Ховд, зүүн бүсээс Дорнод, төвийн болон хангайн бүсээс Орхон, Дархан-Уул зэрэг хүн ам харьцангуй төвлөрсөн газрыг оруулав. Түүврийн нийт тоо 800-аас бүс нутаг тус бүрт 100, нийслэл Улаанбаатар хотод 400 байхаар тус тус сонгов.

Ардчилсан нийгэм, улс төрийн тогтолцоонд шилжиж, шинэ үндсэн хуулиа 1992 онд батлан даган мөрдөж эхэлснээс хойших 17 жилийн хугацаа Монголчуудын хувьд ардчилсан улс төрийн соёл, оролцоонд суралцах, ардчилсан сонгуульд


¹ Судалгааны үр дүнд тулгуурлан “What Supports and Obstructs Political Development of Mongolia?” сэдэвт илтгэлийг 2007 оны 8-р сард Азийн улс төр судлалын Консорциум, Сонг Кунг Их сургууль, Сөүлийн Үндэсний Их сургуулиас хамтран зохион байгуулсан “Toward Political and Social Research with Asian Identity” олон улсын хуралд “Монгол дахь сонгогчдын боловсролын өнөөгийн байдал” сэдэвт илтгэл 2007 оны 9-р сард МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төв, ХБНГУ-ын Конрад Аденаурын Сан, Нээлттэй нийгэм форумаас хамтран зохион байгуулсан “Сонгуулийн компанийн коммуникаци: Өрнөдийн жишиг ба Монгол Улс” сэдэвт ыага хуралд, “Development of Civil Society in Mongolia” сэдэвт илтгэл 2007 оны 11-р сард Солонгосын Нийгмийн Онолын Нийгэмлэг, Корея Их Сргууль, Сөүлийн Үндэсний Их сургуулиас хамтран зохион байгуулсан “Changing Social Reality and Searching for Alternative Social Theories in East Asia” сэдэвт олон улсын бага хурлаар тус тус хэлэлцүүлэн болно.

оролцож, саналаа буюу сонголтоо чөлөөтэй, шууд илэрхийлэхэд суралцаж байгаа хугацаа юм. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн болон орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гэх мэт олон янзын боловч угтаа аль аль нь ардчилсан хууль ёсонд тулгуурлаж, иргэний улс төрийн эрх эрх чөлөөг дээдэлсэн сонгуулиудыг зохион байгуулж оролцож, улс төрийн сонголтын туршлага хуримтлуулж, товчдоо улс төрд суралцаж ирсэн билээ. Энэ хугацаанд сонгуулийн хэлбэр, хэв маягаас төдийлөн хамаарал багатай боловч, нийтлэг ажиглагддаг болсон зүйл бол сонгогч иргэдийн улс төрийн идэвх, тухайлбал сонгуулийн оролцоо сонгууль бүрт буурах хандлага гарч байна. Энэ талаар иргэдийн санаа бодол ямар байгаа болон, оролцооны идэвхийн бууралтыг хэрхэн үнэлж, ямар учир шалтгаантай холбон үзэж байгааг судалгааг тодруулахад үр дүн нь:

- 28.6 хувь нь амьдралд ахиц гарахгүй байгаатай холбож үзсэн бол
- 26.9 хувь нь улс төрчдийн үйл ажиллагаанаас шалтгаалж байна хэмээн,
- 24.5 хувь нь иргэд улс төрөөс залхаж байгаагийн илрэл гэжээ.

Хамгийн өндөр хувь эзэлж буй нь дээрх хариултуудаас үзвэл сонгуулийн оролцооны бууралт нь нийгэм-улс төрийн амьдралд түгээмэл гарч буй сөрөг үзэгдэл тухайлбал, улс төрчдийн нэр хүнд муудах, хүмүүсийн ахуй амьдралын түвшин, чанар улам доошлох, ерөнхийдөө улс төрөөс, улс төржихөөс иргэд залхаж байгаатай шууд уялдаатай үзэгдэл болох нь илт байна. Энэ бүхний үр дагавар нь сонгогчид улс төрийн эрх, эрх чөлөөгөө эдлэх, сонгуульд оролцож саналаа илэрхийлж сонголтоо хийх зэрэгт эсрэгээр нөлөөлж байна гэж дүгнэж болох юм.


Тэгвэл, сонгуульд оролцож, саналаа өгдөг улс төрийн идэвхитэй иргэдийн хувьд нэр дэвшигчдийг ямар үзүүлэлт, шалгуураар сонгодог вэ гэдэг асуудал сонирхолтой болов уу. Зураг 1-ээс харахад нэр дэвшигчийн мэдлэг боловсрол, ажлын туршлага сонголт хийхэд хамгийн гол буюу маш чухалд тооцогддог байна.



Үүгээрээ өнөөгийн Монголын сонгогчид мэдлэг боловсролыг бүхнээс илүүд үзэж, улс төрчидөөс үүнийг хүсэн хүлээдэг болох нь харагдаж байгаа юм. 66.3 хувь нь мэдлэг боловсрол, туршлагыг маш чухалд, дээр нь 25.7 хувь нь чухалд нийтдээ респондентуудын 92 хувь нь мэдлэг боловсролыг үнэлэх нийгмийн эрэлт байгааг илэрхийлж байна. Харин огт чухал бишд тооцож буй үзүүлэлтээс

хамгийн их хувь эзэлж буй нь нутаг усны харьяалал (38.9), гадаад дүр төрх, зан араншин (23.8) тус тус эзэлж байна. Нутаг усны харьяалалд өгч буй ач холбогдол сонгогчдын улс төрийн соёл оролцооны хэв маягт шилжиж буйг, эсвэл ийм сэтгэл зүйн үндэс суурь нэгэнт бий болж байгааг харуулж байгаа болов уу.

Улс төрийн коммуникацийн гол суваг бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл байдаг. Монголд хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, төрөл, цар хүрээ хүн амын тоо, сонгогчдын тоотой харьцуулахад хангалттай хэмжээнд байгаа. Энэ нь ч цаашид өсөх хандлагатай юм. Судалгаанд оролцогчдын хувьд нийгэм, улс төрийн амьдралын талаарх мэдээллээ ямар эх үүсвэрээс голчлон авдаг талаарх дүр зургийг Зураг 2-оос харна уу.



Төрийн удирдлага, бодлого шийдвэрийн талаар иргэд мэдээлэл олж авах боломж багатай байдгийг судалгаанд оролцогчдын үнэлэлт харуулж байна. Тухайлбал, 12 хувь нь мэдээлэл авах боломж сайн, 5 хувь нь мэдэхгүй гэсэн бол үлдсэн 83 хувь нь дунд, бага, огт хангалтгүй байдаг хэмээн үнэлсэн байна. Энэ нь төр засаг үйл ажиллагаагаа ард түмэндээ одоо байгаагаасаа илүү нээлттэй, хүртээлтэй байлгах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна. Тэгээд ч аливаа ардчилсан нийгмийн нэг чухал шаардлага бол төр засгийн үйл ажиллагаа, ил тод, нээлттэй, тунгалаг байх явдал гэдгийг чухалчилж байгаа билээ.

Мэдээлэл авах боломж хомс байгааг илэрхийлсэн дээрх үнэлэлт яагаад хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо хангалттай хэмжээнд байхад гарч ирж байна вэ? үүнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл төр засгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад үүрэг роль бага байгаагийн илрэл үү? Эсвэл төр засаг үйл ажиллагаагаа хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хаалттай явуулж байна уу? Эдгээр асуултын цогц хариулт ганц энэ судалгаагаар гарч ирэхгүй нь тодорхой. Гэвч хэвлэл мэдээллийн хэрэгсэл төр засгийн бодлого, үйл ажиллагааны ил тод байдлыг хангахад үүргээ гүйцэтгэж буй байдлыг судалгаанд оролцогчдын хэрхэн авч үзсэнийг Зураг 3-аас харна уу.

холбогдолтой юм. Иргэдийн улс төрийн боловсрол, соёл, ухамсар дээшлэхийн хэрээр тэдний улс төрд оролцох оролцоо идэвхжинэ.

МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төвөөс эрхлэн явуулсан тандалт судалгаанаас манай орны сонгогчдын боловсрол, үүн дотроо улс төр түүний дотор сонгуулийн талаарх ойлголт, мэдлэгийн түвшин, цар хүрээг тоймлон харж болох юм. Судалгаанд хамрагдагчдын хувийн жин, ардчиллын хөгжилд иргэдийн улс төрийн мэдлэг, боловсролыг чухал зүйл гэж бодож байгаа эсэхийг авч үзсэнийг хүснэгт 1-ээс харна уу.


Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, ардчиллын хөгжилд иргэдийн улс төрийн мэдлэг, боловсролыг чухал зүйл гэж бодож байгаа эсэхээр, сонгосон үзүүлэлтүүдээр

Сонгосон үзүүлэлтүүд	Маш чухал	Тийм ч чухал биш	Огт хэрэггүй	Мэдэхгүй
Хүйс				
Эрэгтэй	78.4	14.4	2.1	5.2
Эмэгтэй	83.5	8.7	1.9	5.8
Насны бүлэг				
18-25	91.9	1.4	-	6.8
26-35	78.4	17.6	-	3.9
36-45	78.0	17.1	2.4	2.4
46-60	68.2	18.2	4.5	9.1
61 ба түүнээс дээш	58.3	16.7	16.7	8.3
Боловсролын түвшин				
Бага	33.3	33.3	33.3	-
Дунд	82.4	7.4	-	10.3
Дээд	82.7	12.6	1.6	3.1
Боловсролгүй	-	50.0	50.0	-
Ажил эрхэлж буй салбар				
Төрийн байгууллага	86.1	13.9	-	-
Хувийн компани, аж ахуйн нэгж	73.5	14.7	-	11.8
Төрийн бус байгууллага	63.6	36.4	-	-
Хувиараа бизнес эрхэлдэг	82.9	11.4	2.9	2.9
Ажилгүй	62.5	18.8	12.5	6.3
Тэтгэвэрт	61.5	15.4	7.7	15.4
Суралцдаг	94.5	-	-	5.5
Өрхийн сарын дундаж орлого				
50000 төгрөг хүртэл	75.0	8.3	8.3	8.3
50001-100000	75.0	8.3	2.8	13.9
100001-300000	81.1	13.3	1.1	4.4
300001-500000	84.4	11.1	2.2	2.2
500001 төгрөгнөөс дээш	88.2	11.8	-	-
Бүгд	81.0	11.5	2.0	5.5

Эндээс харвал насны бүлгийн хувьд ерөнхийдөө бүхий л насныхан улс төрийн мэдлэг, боловсролтой байхад нэлээн өндөр ач холбогдол өгч байгаа

боловч насны бүлэг ахих тусам ардчиллын хөгжилд улс төрийн мэдлэг боловсролыг маш чухалд тооцох хүмүүсийн хувь буурч байгаа нь харагдаж байна. Харин боловсролын түвшний хувьд харвал судалгаанд ерөнхийдөө дээд боловсролтой хүмүүс түлхүү хамрагдсан бөгөөд үүнийг ч асуулгын хариу авах гол чиглэлээ болгож ажилласан гэдгийг дурьдах хэрэгтэй юм. Ажилгүй иргэдийн 12.5 хувь нь энэ асуудлыг огт хэрэггүй гэж үзсэнийг эс анзаарвал ажил эрхэлж буй салбарын тухайд бүхий л салбарын хувьд тэтгэвэрт байдаг мөн ажилгүй иргэдийг оролцуулаад улс орны ардчилсан хөгжил дэвшилд иргэдийн улс төрийн талаарх мэдлэг, боловсрол чухал гэж дийлэнх олонх нь үзжээ. Үүн дотроо суралцдаг буюу оюутан залуусын туйлын олонх нь буюу 94.5 хувь нь маш чухал гэж хариулсан байгаа нь боловсрол мэдлэгт тэдний зүгээс өгч буй үнэлгээ, ач холбогдлын хэр хэмжээг илэрхийлсэн үзүүлэлт болжээ гэж дүгнэхээр байна. Орлогын түвшин өндөр байх тусмаа улс төрийн мэдлэг боловсролд ач холбогдол илүү өгөх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал өрхийн сарын орлого нь хагас сая төгрөгөөс илүү респондентууд улс төрийн мэдлэг, боловсрол *огт хэрэггүй* гэж *үзээгүйг* харж болно.

Ийнхүү улс төрийн мэдлэг, боловсролд өндөр ач холбогдол өгч, үүнийгээ улс орны ардчилсан хөгжлийн ирээдүйтэй холбон ойлгож буй респондентуудын хувьд өөрсдөө улс орны эдийн засаг, улс төрийн зарим тулгамдсан асуудлуудын талаар ямар байр суурь, үзэл бодолтой байгааг тандаж үзэхэд дараах үр дүн гарч ирж байна. Тухайлбал, өнөөгийн улс орны эдийн засгийн байдлыг хэрхэн үнэлж байгаа талаар тандахад дийлэнх олонх нь буюу 63 хувь нь тааруу, 21 хувь нь муу гэж үзсэн буюу нийтдээ 84 хувь нь таагүй үнэлгээ өгсөн байх юм. Зураг 5.-г үзнэ үү. Дөнгөж 1 хувь нь маш сайн 11 хувь нь хангалттай гэж боддог байна.




Түүнчлэн, өнөөгийн Монголын улс төрийн намуудын төлөвшлийг хэрхэн үнэлж байгааг асуухад бага боловсролтой оролцогчид хамгийн өндөр буюу 66.7 хувь нь жам ёсоороо явагдаж байна гэж үзсэн бол дээд боловсролтой оролцогчид илүүтэйгээр (48.8%) огт төлөвшиж чадахгүй байна гэж үзсэн байна. Үүнийг хүснэгт 2-оос харна уу. Энэ нь улс төрийн намын төлөвшилийн асуудалд хандах хандлагын ялгааг илэрхийлэхээс гадна энэ талаарх ойлголт, мэдлэгийн түвшин хэр зөрүүтэй байгааг харуулж байна гэж тайлбарлаж болно.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, Монголын улс төрийн намуудын төлөвшлийг үнэлж байгаа байдал, сонгосон үзүүлэлтүүдээр


Сонгосон үзүүлэлтүүд	Жам ёсоороо явагдаж байна	Хэт удаан байна	Огт төлөвшиж чадахгүй байна	Мэдэхгүй
Хүйс				
Эрэгтэй	14.4	22.7	48.5	14.4
Эмэгтэй	13.6	30.1	46.6	9.7
Насны бүлэг				
18-25	14.9	24.3	48.6	12.2
26-35	13.7	21.6	51.0	13.7
36-45	9.8	31.7	46.3	12.2
46-60	18.2	31.8	40.9	9.1
61 ба түүнээс дээш	16.7	33.3	41.7	8.3
Боловсролын түвшин				
Бага	66.7	-	33.3	-
Дунд	13.2	26.5	47.1	13.2
Дээд	13.4	26.8	48.8	11.0
Боловсролгүй	-	50.0	-	50.0
Ажил эрхэлж буй салбар				
Төрийн байгууллага	8.3	38.9	38.9	13.9
Хувийн компани, аж ахуйн нэгж	8.8	29.4	47.1	14.7
Төрийн бус байгууллага	9.1	36.4	36.4	18.2
Хувиараа бизнес эрхэлдэг	17.1	20.0	54.3	8.6
Ажилгүй	12.5	12.5	62.5	12.5
Тэтгэвэрт	23.1	15.4	53.8	7.7
Суралцдаг	18.2	25.5	45.5	10.9
Бүгд	14.0	26.5	47.5	12.0

Тандалт судалгаанд оролцогчдын талаас илүү нь олон намын систем манай улсад тохиромжтой гэж үзсэн байна (52%). Нэг намын болон хоёр намын системийг дэмжсэн респондентуудын хувь үүнээс нэлээн бага бөгөөд хоорондоо ойролцоо байгааг Зураг 6-гаас харна уу. Ерөнхийд нь олон намын систем түүнийг дэмжсэн сонгуулийн системийн хувьд олон нийтийн хүлээлт тодорхой хэмжээнд байгааг энэ дүн харуулж байна.



Олон намын системийг түлхүү дэмжиж буй дээрх байдал өнөөгийн улс төрийн амьдралд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй том, жижиг, парламентад

суудалтай ба суудалгүй намуудыг дэмжих дэмжлэг тарамдсан, тархсан байдалтай байгаатай басхүү холбогдож байна. Үүнийг Зураг 7-гоос харна уу.



Эндээс харахад, аль ч намын хувьд дэмжигчдын тооноос сонголтоо хийж амжаагүй буюу аль нэг намыг илт дэмжсэн сонголтоо хараахан хийгээгүй оролцогчдын тоо илүү байна. Харин намуудын хувь рейтингээрээ парламентын голлох хоёр нам харьцангуй илүү байна. Тухайлбал, маргааш УИХ-ын сонгууль болбол респондентуудын 28.5 хувь МАХН-д, 24 хувь нь АН-д саналаа өгөх төлөвтэй байна.

Засгийн газраас нэн тэргүүнд ямар асуудлыг шийдвэрлэх шаардлагатай вэ? Энэ асуултанд судалгаанд оролцогчид хэрхэн хариулсныг Хүснэгт 3-аас үзнэ үү. Эндээс харвал ажлын байр нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах үнийн өсөлтийг зогсоох зэрэг асуудал хүмүүсийн санааг хамгийн их зовоож байгаа бөгөөд Засгийн газрын зүгээс авах арга хэмжээгээр тэдгээрийг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байгаа нь харагдаж байна. МУИС-ийн Орчин үеийн улс төрийн судалгааны төвөөс явуулсан авилгалын талаарх судалгаанд авилгалын асуудал монголчуудын хувьд сэтгэл түгшээсэн нэн түрүүн шийдвэрлэвэл зохих асуудлын тэргүүн хэсэгт байсан бол ажилгүйдэл, ядууралтай холбоотой асуудлууд авилгалаас илүү шийдвэрлэх шаардлагатай болж иржээ.

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, Засгийн газраас нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлсон байдлаар	
Засгийн газраас нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай асуудлууд	Хувь
Ажлын байр нэмэгдүүлэх	30.0
Ядуурлыг бууруулах	22.0
Үнийн өсөлтийг зогсоох	14.0
Авилгалтай тэмцэх	10.0
Орон сууцаар хангах	9.0
Цалин тэтгэвэр нэмэгдүүлэх	6.5
Татварын шударга тогтолцоотой болгох	4.5
Архидалт, гэмт хэрэгтэй тэмцэх	2.5
Цөлжилтөөс хамгаалах	0.5
Мэдэхгүй	1.0
Нийт	100.0

Мөн түүнчлэн, ямар засгийн газрыг илүүд үздэг талаар судлаж үзэхэд нэг намын засгийн газар гэж судалгаанд оролцогсодын 25.5 хувь нь үзсэн бол эвслийн засгийн газар гэж 44 хувь, аль нь ч болно гэж 19.5 хувь, мэдэхгүй гэж 11 хувь нь тус тус хариулжээ.


Ингэхэд Монголын сонгогчид сонгуульд оролцож аль нэг улс төрийн нам, нэр дэвшигчийн төлөө саналаа өгөхдөө ямар хүчин зүйлийг голчлон харгалзаж үздэг вэ? Тандалт судалгаагаар нэр дэвшигчийн мэдлэг боловсрол, ажил мэргэжлийн туршлага хамгийн гол хүчин зүйлээр тооцогдож байна. Судалгаанд оролцогсодын 56 хувь нь энэхүү хүчин зүйлийг харгалзаж байж сонголтоо хийдэг нь тандалт судалгаанаас харагдаж байна. Үүний дараагаар нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, амлалт (20.5%) болон улс төрийн намын харьяалал, гишүүнчлэлийг (13.5%) чухалд тооцон харгалан үзнэ гэдгээ респондентууд илэрхийлжээ. Харин нэр дэвшигчийн нутаг усны харьяалал, гадаад дүр төрх, зан төлөв, сонгуулийн кампанит ажил, ухуулга сурталчилгаа зэргийг төдийлөн чухалчилдаггүй болох нь судалгааны дүнгээс харагдаж байна. Үүнийг Хүснэгт 4-өөс харна уу.

Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, сонгуульд санал өгөхдөө хамгийн чухалд тооцдог хүчин зүйлээр	
Сонгуульд санал өгөхөд хамгийн чухалд тооцдог хүчин зүйлс	Хувь
Нэр дэвшигчийн намын харьяалал, гишүүнчлэл	13.5
Нэр дэвшигчийн мэдлэг боловсрол, ажлын туршлага	56.0
Нэр дэвшигчийн гадаад дүр төрх, зан төлөв	4.0
Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, амлалт	20.5
Сонгуулийн кампанит ажил, ухуулга сурталчилгаа	4.5
Нэр дэвшигчийн нутаг усны харьяалал	1.5
Нийт	100.0

Иргэд сонгогчид өөрсдийн ашиг сонирхлоо илэрхийлэхэд аль хэлбэр нь илүү нөлөөтэй талаарх үзэл бодлыг тандаж үзэхэд жагсаал цуглаан 12.5%, өргөх бичиг 9.5%, сонирхлын бүлэг-иргэний хөдөлгөөнд нэгдэх 18%, өлсгөлөн зарлах 10.5%, ҮЭ-д нэгдэх 8.5%, улс төрийн намыг дэмжих 6.5%, сонгуульд оролцож саналаа өгөх 16%, мэдэхгүй гэж 18.5% нь тус тус хариулсан дүн харагдаж байна.

Эцэст нь, тандалт судалгаагаар Монголын ардчиллын түвшинг хэрхэн үнэлж байгааг судалж үзэхэд дунд зэрэг гэсэн хариулт дийлэнх олонхи (62%) байгаа нь бидний ардчиллын үнэлгээ тийм ч хангалттай сайн биш байгааг харуулж байна.

Зураг 8. Судалгаанд хамрагдсан хүн амын хувийн жин, Монголын ардчиллын түвшинг үнэлж байгаа байдлаар



Гэвч онц ба сайн гэсэн үнэлгээний нийлбэр (21.5%) муу гэж үнэлсэн хариулагчдаас илүү (12%) байгаа нь ардчиллын нэр хүнд, үнэлэмж найдвараа хараахан алдаагүй, иргэд сонгогчид ардчилалд өөдрөг хандах итгэлээ алдаагүй байгаа гэсэн найдлага төрүүлж байгаа юм.

Дүгнэлт ба зөвлөмжүүд

МУИС-ийн Азийн Судалгааны Төвийн санхүүжилтээр хийгдсэн “Монгол дахь сонгогчдын боловсрол” хэмээх энэхүү төслийн хүрээнд хийгдсэн судалгаануудын үр дүн, түүний хэлэлцүүлэг, эрдэмтэд судлаачдын санал дүгнэлт зэрэгт үндэслэн дараах дүгнэлт, зөвлөмжийг хийж болохоор байна.

Иргэд улс төрийн мэдлэг, боловсролыг хэр зэрэг хүсэн хүлээдэг, тэдэнд сонголтоо хийх, улс төрд оролцох, улс төрийн амьдралын талаар ойлголт, төсөөлөлтэй болоход энэ чиглэлийн сургалт сурталчилгаа чухал шаардлагатай байгааг харуулж байна. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн болон орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гэх мэт олон янзын боловч угтаа аль аль нь ардчилсан хууль ёсонд тулгуурлаж, иргэний улс төрийн эрх эрх чөлөөг дээдэлсэн сонгуулиудыг зохион байгуулж оролцож, улс төрийн сонголтын туршлага хуримтлуулж, товчдоо улс төрд суралцаж ирсэн билээ. Энэ хугацаанд сонгуулийн хэлбэр, хэв маягаас төдийлөн хамаарал багатай боловч, нийтлэг ажиглагддаг болсон зүйл бол сонгогч иргэдийн улс төрийн идэвх, тухайлбал сонгуулийн оролцоо сонгууль бүрт буурах хандлага гарч байна. Энэ талаар иргэдийн санаа бодол ямар байгаа болон, оролцооны идэвхийн бууралтыг хэрхэн үнэлж, ямар учир шалтгаантай холбон үзэж байгааг судалгааг тодруулахад сонгуулийн оролцооны бууралт нь нийгэм-улс төрийн амьдралд түгээмэл гарч буй сөрөг үзэгдэл тухайлбал, улс төрчдийн нэр хүнд буурах, хүмүүсийн ахуй амьдралын түвшин, чанар улам буурах, ерөнхийдөө улс төрөөс, улс төржихөөс иргэд залхаж байгаатай шууд уялдаатай үзэгдэл болох нь илт байна. Энэ бүхний үр дагавар нь сонгогчид улс төрийн эрх, эрх чөлөөгөө эдлэх, сонгуульд оролцож саналаа илэрхийлж сонголтоо хийх зэрэгт эсрэгээр нөлөөлж байна гэж дүгнэж болох юм.

Монголчууд улс төрийн мэдлэг, мэдээллийг хүсэн хүлээдэг, энэ талаарх эрэлт хэрэгцээ нийгмийн ухамсрын түвшинд өндөр байгааг судалгааны дүн нотолж байна. Нөгөөтэйгүүр, улс төрийн мэдлэг, боловсролд өндөр ач холбогдол өгч, үүнийгээ улс орны ардчилсан хөгжлийн ирээдүйтэй холбон үзэж байна. Тиймээс ч судалгаанд оролцогчидын хувьд улс орны эдийн засаг,

нийгэм, улс төрийн зарим тулгамдсан асуудлуудын талаарх байр суурь, үзэл бодлоо илэрхийлсэн байдал нь сонгогчидын боловсрол, мэдлэг, ойлголтын түвшин, цар хүрээнээс хамаарч судалгааны асуудлуудад хандах хандлага ялгаатай гарч ирж байна.

Сонгогчид нэр дэвшигчдийг ямар үзүүлэлт, шалгуураар сонгодог болохыг тоон судалгааны болон тандалт судалгааны дүнгээс харьцуулан дүгнэж үзэхэд, нэр дэвшигчийн мэдлэг боловсрол, ажлын туршлага сонголт хийхэд хамгийн гол хүчин зүйлд тооцогдож байна. Үүгээрээ өнөөгийн Монголын сонгогчид мэдлэг боловсролыг бүхнээс илүүд үзэж, улс төрчидөөс үүнийг хүсэн хүлээдэг болох нь харагдаж байгаа юм. Эхний судалгаагаар энэ хүчин зүйлд ач холбогдол өгч буй респондентын хувь 66.3 байсан бол тандалт судалгаагаар 56.0 хувь гарсан байна. Харин аль аль судалгааны дүнгээс харахад нэр дэвшигчийн нутаг усны харьяалал, гадаад дүр төрх, зан төлөв, сонгуулийн кампанит ажил, ухуулга сурталчилгаа зэргийг төдийлөн чухалчилдаггүй байна. Нутаг усны харьяалалд өгч буй ач холбогдол сонгогчдын улс төрийн соёл оролцооны хэв маягт шилжиж буйг, эсвэл ийм сэтгэл зүйн үндэс суурь нэгэнт бий болж байгааг харуулж байгаа болов уу.

Иймд улс төрийн намууд, нэр дэвшигчид сонгогчидын боловсролын энэ түвшин, мөн улс төрийн соёлын дэвшилт өөрчлөлтүүдийг сонгуулийн үйл ажиллагаандаа харгалзан үзэхийн зайлшгүйг нотолж байгааг төслийн судалгааны дүгнэлтээр илэрхийлж болж байна.

Ном зүй

Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын 5-р бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх төсөл. Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ. УБ., 2006
Монгол Улсын Боловсролын тухай хууль, 2002

Монгол Улсын Үндсэн Хууль, УБ., 1992

Улс төрийн боловсролын академи, Зүүн Азийн барометер. Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа, УБ., 2005.

Cain, Bruce, John Ferejohn and Morris Fiorina. 1987. *The Personal Vote: Constituency Service and Electoral Independence*. Cambridge, MA; Harvard University Press.

Farrell, David. 2001. *Electoral Systems: A Comparative Introduction*. London: Palgrave.

Fish, Steven M. 1998. "Mongolia: Democracy without Prerequisites," In *Journal of Democracy*. 9 (3), 127-141.

National Statistical Office of Mongolia. 2005. *Monthly Bulletin of Statistics*. June. Ulaanbaatar: National Statistical Office of Mongolia.

Putnam, Robert D. 1993. *Making Democracy Work: Civic Traditions in Modern Italy*. Princeton, NJ: Princeton University Press.

U.S. Department of State. 1991. *What is Democracy?* October, 4.

“НАМЫН СИСТЕМИЙН ЭМПИРИК ШИНЖИЛГЭЭ”*

Д.Болд-Эрдэнэ

(Философи социологий эрхийн хүрээлэнгийн улс төрийн)

Харьцуулсан улс төр судлалд намын системийн эмпирик судалгаа нь сонгуулийн болон парламентын түвшин дэх намын систем, сонгуулийн хүчин зүйл, нийгмийн хийгээд төрийн системийн хоорондын харилцан хамаарлыг нээн харуулахад чиглэгддэг. Хэдийгээр албан ёсоор бүртгэгдсэн бүх намууд улс төрийн системд багтдаг ч сонгууль болон парламентад суудал хувиарлах явцад улс төрийн бодитой үйл ажиллагаа явуулах намын тоо эрс цөөрдөг. Түүгээр ч барахгүй сонгуулийн болон парламентын түвшинд бүх намууд бодитой, үр ашигтай байж чаддаггүй. Үүнтэй холбогдуулан парламент дахь намын задралын түвшинг (парламентын фракцчлагдах үйл явцыг) тодорхойлох хүчин зүйлийн тухай асуудлыг судлах хэрэгтэй болдог. Ийм төрлийн эмпирик шинжилгээний зарим нэг тодорхой жишээг авч үзье.

Парламентын фракцчлагдах үйл явцын нөхцөл байдлын шинжилгээ. Улс төрийн олон ургальч үзэл нь ардчилсан системийн үзүүлэлт болохын хувьд төвөгтэй хэцүү нөхцөл байдлыг тогтвортой болгох шилжилтийн тодорхой зааг хягаартай байдаг. Тиймээс харьцуулсан улс төр судлалд улс төрийн бүтцийн задралын асуудал чухал байр эзэлдэг. Ингэж судлахдаа зөвхөн парламент болон намын системийн ялгаралын үзүүлэлтийг төдийгүй тэрхүү улс төрийн ялгаралд нөлөөлөгч *шалтгаан нөхцөлийг* тодорхойлохыг оролддог. Ийм төрлийн судалгааны нэг нь Пауэллийн 1965-1976 оны хооронд явуулсан 27 орны (84 сонгуулийн тохиолдол) парламентын намуудын фракцын асуудлын судалгаа юм. (Powell, 1982.) Тэрээр парламентуудын задралын түвшинг тодорхойлох хүчин зүйлсэд *сонгуулийн системийн онцлог, нийгмийн социаль ялгарал, төрийн засаглалын хэлбэр* зэргийг онцолсон байдаг. Улс төрийн намууд нь өвөрмөц ашиг сонирхолуудыг төлөөлж, тэдгээрийг сонгогдсон төлөөлөгчдөөрөө уламжлан парламентад илэрхийлдэг учраас парламентийн намуудын фракцчлагдах түвшин нь нийгмийн бүтцийн задрал ялгарлын түвшингөөр тодорхойлогддог болох нь уг судалгаагаар харагджээ.

Парламент дахь намуудын тоог тодорхойлдог нэг чухал хүчин зүйл нь сонгуулийн системийн шинж байдал юм. Бүр 50-иад оны үед Морис Дюверже сонгуулийн системүүд нь намын системд харилцан адилгүй байдлаар нөлөөлдөг болохыг тогтоосон байна.* (Duverger, 1954) Тэрээр сонгуулийн плюраль систем (эсвэл нэг шаттай мажоритар систем) нь хоёр намын систем бүрэлдэхэд хамгийн хүчтэй нөлөөлдөг болохыг нотолсон байна. Хэдийгээр хоёр намаас гадна улс төрийн бусад намууд байдаг ч тэдгээр нь улс төрийн үйл явцад тодорхойлогч, шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж чаддаггүй. Нөлөө үзүүлэгч гуравдагч хүчин зүйл нь ерөнхийлөгчийг бүх ард түмнээс шууд эсвэл дам сонгодог төрийн засаглалын ерөнхийлөгчийн систем юм. Энэ судалгаанд ялган үзсэн хувьсагчийн задаргааг хийхдээ дараах арга хандлагыг хэрэглэсэн.

* Nīdaoīā Ē.Ā. “Nīadaīāīāy nāaīēoāēuīāy nēēoīēīāēy” (Ī., 2002) mīn Ā.Āīēā-Ūdāyūy oūnyā-ēy īd-ōōēāā.

* Ōdāīōūī oēn o°dēēī oēīāēyō oōāāīū ydāyūdyī īīdēn Ārāādāēā nīāoōēēēī nēnōāīī ūēēī īāīūī nēnōāīā ūēēyō rē°ēēēēā oōnāāēēāī nōāāēē, oūāyūyūōēēī ūō āāāāāādūī cūē dīādēūā īyūī dādōōēnāī āāēāāā. ūīēēā oēn o°dēēī oēīāēyō oōāāīū īī āēōyūēēēyāyā “ Ārāādāēāīēēī oōōēū ” oūyūyī nīōīēāīā. Ī.Ārāādāēā ūīēēāyū “nīōēīēīāēēī oōōēū” āyā īyōēyūyī āāēāāā. (Ā.Ā)

Парламентын фракцчлагдах үйл явцын *хамааралт хувьсагчийг* тусгай индекс болох - *Rae-гийн индексээр*** тодорхойлбол:

$$\text{Индекс } Rae = 1 - \sum S_i^2,$$

S_i -суудлын хувь, i –парламент дахь нам.

Тухайн индексийг анх Дуглас Рай “*Сонгуулийн эрхийн улс төрийн нөхцөл*” (Rae, 1967) хэмээх номондоо намын системд сонгуулийн системийн үзүүлэх нөлөөллийг иж бүрэн харьцуулан судалсан судалгаандаа хэрэглэсэн байна. *Rae-гийн индексийг* ашигласан тодорхой жишээг авч үзье:

1983 оны 3-р сард болсон ХБНГУ-ын Бундестагийн сонгуулиар парламентын доод танхимд санал болон суудлыг дараах байдлаар хувиарласан байна.

(Таблиц 11-ыг үз)

ХБНГУ-ын парламент дахь сонгогчдын санал, суудлын хуваарилалт (1983 он)*

НАМУУД	Саналын хувь (%)**	Суудлын тоо	Суудлын хувь (%)
<i>Христосын-ардчилсан холбоо (Христосын –нийгмийн холбоо)</i>	48,8	244	49,0
<i>Социал-демократ нам</i>	38,2	193	38,8
<i>Чөлөөт ардчилсан нам</i>	7,0	34	6,8
<i>“Ногоонтнууд”</i>	5,6	27	5,4
<i>Үндэсний ардчилсан нам</i>	0,2	0	0
<i>Коммунист нам</i>	0,2	0	0
<i>Бусад</i>	0,1	0	0
<i>ДҮН</i>	100	498	100

* **Эх сурвалж:** Leonard, Natkiel, 1985. p.59.

** *Намын жагсаалтаар санал өгсөн үр дүнгүүдийг үндэслэн саналуудын хувиарлалтыг хийсэн.*

$$\text{Индекс } Rae = 1 - (0,24 + 0,15 + 0,005 + 0,003) = 1 - 0,4 = 0,6.$$

Жишээ нь: Японтой харьцуулахад (1983 оны сонгуульд индекс Rae =0,67 байсан) ХБНГУ-д парламентын намуудын фракцжилтийн түвшин доогуур, гэхдээ АНУ-аас (1984 оны төлөөлөгчдийн танхимын сонгуульд 0,49 байжээ) өндөр байна.

Пауэллийн судалгаанд *хамааралгүй хувьсагчид (чөлөөт хувьсагчид Д.Б)* өөрөөр хэлбэл нөлөө үзүүлэгч хүчин зүйлс нь дараах индикаторуудаар илэрхийлэгдсэн болно:

(1) *Угсаатны ялгарал:*

Үүнийг мөн *Rae-ын индексийн (итгэлцүүрийн)* тусламжтай тооцоолсон.

$$\text{Индекс } Rae = 1 - \sum g_i^2, \text{ энд}$$

g_i -хүн амын бүрэлдэхүүн дэх i - угсаатны бүлгийн жин.

(2) *Хөдөө аж ахуйн хүн амын индекс :*

** Оа еіааеηееа Аоаеаη Дае іаііі ηеηδаіа ηіаіаоёеёеі ηеηδаі оуδоуі і°е°еа°аеаа ηоаеаδ уаоааа ηаηае аіеаіηіі о:ед о;і;іеё іуδууδ іуδеуо аіеηіі. (Ä.Ä)

Хөдөө аж ахуйн хүн амыг хэмжихийн тулд 1-3 хүртлэх шкал (шатлал)-ыг ашигласан. Түүнийг хөдөө аж ахуйн хүн амын хувийн жинтэй дараах байдлаар харьцуулсан байна.

- 5 – 19 % Хөдөө аж ахуйн хүн амын -1
- 20 - 49 % Хөдөө аж ахуйн хүн амын – 2,
- 50- 80 % Хөдөө аж ахуйн хүн амын нь – 3,

(3) Католик шашинтай хүн амын индекс :

Католик хүн амыг хэмжихийн тулд 1- 3 хүртлэх шатлалыг ашигласан. Түүнийг өмнөх индексийн нэгэн адил католик шашинтай хүн амын хувийн жинтэй харьцуулж үзсэн :

- 5 -19 % Католик шашинтай хүн амын – 1,
- 20– 49 % Католик шашинтай хүн амын – 2,
- 50- 80 % Католик шашинтай хүн амын – 3,

(4) 1- 3 гэсэн шатлалаар тооцож үзсэн сонгуулийн системийн “Хүч нөлөө”.

Шатлалын тоонуудыг сонгуулийн системийн төрлүүдтэй дараах байдлаар харьцуулан үзсэн :

- Нэг мандаттай тойрог бүхий сонгуулийн плюраль систем -3,
- Холимог систем – 2,
- Хувь тэнцүүлсэн (пропорцианал) систем – 1 .

(5)) 0 – 1 гэсэн шатлалаар үнэлэсэн төрийн засаглалын хэлбэрүүд :

- Төрийн засаглалын Ерөнхийлөгчийн хэлбэр - 1,
- Төрийн засаглалын бусад хэлбэрүүд - 0

Олон янзын бууралтууд (регресс)-ыг ашиглан судлаачид парламентын фракцчлагдах үйл явцад *мажоритар бус сонгуулийн систем, бүх төрлийн ялгаралын үйл явцууд, төрийн засаглалын ерөнхийлөгчийн систем* зэрэг нь нөлөөлдөг болохыг баталжээ.

Сонгуулийн болон парламентын намуудын үр ашигтай тоог судалсан нь.

Олон намын систем дэх сонгуулийн үйл явцын судалгаа нь сонгуулийн явцад бүх нам нөлөө үзүүлдэггүй, тэдгээрээс бүгд сонгогдож чаддаггүйг харуулсан. Парламент дахь намуудын суудал хуваарилалт нь эрх мэдлийн хуваарилалт, төлөөллийн байгууллагын үйл ажиллагаанд парламентийн намуудын үзүүлэх нөлөөлөлд өөрчлөлт оруулдаг. Хууль бүтээх үйл ажиллагаанд саадгүйгээр оролцож, төрийн бодлогод бодитой нөлөөлөхийг намуудын “*үр ашигтай тоо*” хэмээн нэрлэдэг бөгөөд энэ нь сонгуульд оролцсон намуудын бүх тооноос сонгогдсон нь цөөн байх тохиолдол юм. “*Намуудын үр ашигтай тоо*” -ны индексийг 1979 онд анх удаа Макку Лааксо, Рейном Таагепера нар санал болгожээ. (Laakso, Taagepera, 1979). Р. Таагепера, М.Шугарт нар бичихдээ: “ бүх байгаа намуудын тоог бус, харин намуудын үр ашигтай тоог ашиглахын давуу тал нь ач холбогдол бүхий намуудыг, ач холбогдол багатай намуудаас ялгаж салгах оновчтой арга юм. Индексийн томъёо нь квадратад дэвшүүлэх замаар нам нэг бүрийг жигнэдэг. Хамгийн бага намын төлөөлөлийн индекс сул байдаг бол бусдаас том намынх нь оролцоо их байдаг” (Таагепера, Shugart, 1993, p. 445) хэмээсэн байдаг.

Тэдний санал болгосон томъёо нь:

$$N = 1 / \sum_{i=1}^n P_i^2$$

Энд P_i -i дэх намын авсан суудлын жин.

Дээр тэмдэглэснээр энэ индекс нь тогтвортой хувьсагчийн тархалт (дисперс)-ыг хэмжинэ. Түүний статистик утга нь хэв загвар (мода) зэрэг үзүүлэлтүүдээр хэмжигддэг судлаж буй хувьсагчийн төв хандлагыг тойрсон тохиолдлуудын төвлөрлийн түвшинг тодорхойлдогт оршдог.

Улс төрийн шинжлэх ухаанд энэ хэмжигдэхүүн нь эдийн засгийн ном бүтээлүүдээс орж ирсэн байна. Үүнийг 60-аад оны эхэн үеэс Хердфиндалийн индексийн тусламжтайгаар (Herfindahl-index) аж үйлдвэрийн салбарын компаниудын төвлөрлийг хэмжихэд хэрэглэж байжээ. Дисперсийн тогтвортой /номиналь / хэмжигдэхүүн нь зөвхөн нэг компани эсвэл нэг нам л байх тохиолдолд хамгийн бага хэмжээндээ хүрдэг байна. Эндээс төвлөрөлийн хэмжигдэхүүний хамгийн бага үнэлгээ 1 байна. Хэрэв бүх компаниуд эсвэл намууд ижил ач холбогдолтой байсан бол n компаниудтай эсвэл n намуудтай тогтвортой хувьсагчийн хувьд хамгийн их байх дисперс нь тэнцүү байх байсан болно.

Үүний дараагаар компартивист судлаачид энэхүү “үр ашигтай тоог” сонгуулийн үйл явцын болон парламент дахь суудал хуваарилалтанд тооцож үзэхээр шийдсэн байна. Тэдгээр нь улс төрийн үйл явцад жинтэй нөлөө үзүүлдэг намуудын тоог илэрхийлж болохуйц сонгуулийн намуудын үр ашгийн тоо (effective number of party votes-ENPV) ба парламентын намуудын үр ашгийн тоо (effective number of party seats-ENPS) хамааралтай хувьсагчдын хувьд эдгээр үзүүлэлтүүдийг олон судлаачид авч үзсэн байна. (Жишээ нь, Lijphart, 1984, Ordeshook and Shvetsova, 1994; Neto, Cox, 1997; Taagepera, 1999). Тухайн хувьсагчдыг дараах индексүүдээр хэмждэг.

1. Сонгуулийн намуудын үр ашигтай тоо (ENPV):

$$ENPV = 1 / \sum_{i=1}^n v_i^2$$

v_i –сонгуульд I -намын авсан саналын хувь хэмжээ.

2. Парламентын намуудын үр ашигтай тоо (ENPS):

$$ENPS = 1 / \sum_{i=1}^n s_i^2$$

Энд s_i -i дэх намын авсан парламентын суудлын жин

Жишээ: 1983 оны гуравдугаар сард болсон Финляндийн парламентын сонгуулийн үр дүнд зориулан сонгуулийн ба парламентын намуудын үр ашигтай тоог тооцоолъё.

Финлянд улсын парламентын сонгуулийн үр дүн (1983 он)

Намууд	Саналын тоо	Хувь	Суудлын тоо	Хувь
Социал демократ нам	795.953	26.7	57	28.5
Үндэсний эвслийн нам	659.078	22.1	44	22.0
Төвийн нам**	525.207	17.6	38	19.0
Ардын ардчилсан холбоо	416.270	13.8	27	13.5
Хөдөө аж ахуйн нам	288.711	9.7	17	8.5
Шведийн ардын нам	146.881	4.9	11	5.5
Христийн холбоо	90.410	3.0	3	1.5

Үндсэн хуулийн нам	11.104	0.4	1	0.5
“Ногоонтнууд”	42.045	1.4	2	1.0
Бусад	4.035	0.1	0	0.0
Бүгд	2.979.694		200	

* Эх үүсвэр: Leonard, Natkiel, 1986.p.49.

**Либераль нам орсон.

$$ENPV=1/0.267^2+0.221^2+0.176^2+0.138^2+0.097^2+0.049^2+0.03^2+0.004^2+0.014^2+0.001^2$$

$$=1/0.0713+0.0448+0.031+0.019+0.0094+0.0024+0.0009+0.0+0.0002+0.0=1$$

$$/0.183=5.46$$

$$ENPS=1/0.285^2+0.22^2+0.19^2+0.135^2+0.085^2+0.055^2+0.15^2+0.005^2+0.01^2=1/0.0812+$$

$$0.0484+0.0361+0.0182+0.0072+0.003+0.0002+0.0+0.0001=1/0.1944=5.14$$

Тооцооноос харахад Финляндийн 1983 оны парламентын намуудын үр ашигтай тоо электораль намуудын үр ашигтай тооноос ялимгүй ч гэсэн бага байна.

Энэ нь Финлянд улс суудал хуваарилахдаа D'Hondt-н томъёог ашиглан пропорционал төлөөллийн үндсэн дээр парламентаа сонгодогтой холбоотой. Бусад улс орнуудад ENPV ба ENPS хоорондын зөрүү их байж болно. Жишээ нь 1981 онд Францад сонгуулийн намуудын үр ашигтай тоо 4,13 харин парламентын намуудын үр ашигтай тоо 2,68 байсан байна. Энд гол учир нь 1986 он хүртэл Франц улсад парламентын доод танхимын сонгуульд мажоритар сонгуулийн хэлбэрийг хэрэглэж байсан ба ялалт байгуулахын тулд 50%-иас дээш санал авах ёстой. Хэрэв эхний үед аль нэгэн нэр дэвшигч шаардлагатай санал аваагүй тохиолдолд хоёр үе шаттай санал хураадаг байсан байна. Энэхүү хоёр үзүүлэлтийн ялгаа нь улс төрийн плюрализм, парламент дахь суудлын хуваарилалт, улс төрийн намуудын хувьд сонгуулийн өндөр босготой байх зэргээр мөн тодорхойлогдож болно.

Харьцуулан судлах судалгааны практикт янз бүрийн улс төрийн системүүд дэх сонгуулийн саналын хуваарилалт болон засаглалын төлөөллийн байгууллагуудын суудал хуваарилалтын хооронд байдаг диспропорцианал / хувь тэнцэлгүй / байдлыг судлах тусгай хэмжүүрүүдийг ашигладаг. Ингэхдээ хувь тэнцүүлсэн байдлыг хадгалахад анхнаасаа л хүндрэлтэй байдаг боловч түүнд сонгуулийн системүүд ба санал тооцох аргууд нөлөө үзүүлдэг. Хувь тэнцэлгүй байдлын **индексийн** өргөн хэрэглэгддэг хоёр индекс байдаг. Анхных нь Дуглас Райн боловсруулсан индекс (Rae, 1967.p.84-86) юм. Энэхүү индекс нь (I) хамгийн багаар бодоход 0,5 хувь санал авсан бүх намуудын бүх саналын хувь ба суудлын хувь хоорондын модуль зөрүүг тооцоолоход үндэслэдэг. Энэхүү зөрүүний нийлбэрийн дундаж хэмжээг олох энэ үзүүлэлт нь хувь тэнцэлгүй байдлыг харуулдаг. Тэрбээр нэг электораль намд ногдож буй илүү болон дутуу төлөөллийн дундаж хувийг харуулдаг. Энэ хэмжигдэхүүн өндөр байх тусам системд илүү их хувь тэнцвэргүй байдал ажиглагддаг.

$$I = \frac{1}{n} \sum_{i=1}^n |V_i - S_i| \quad \text{Энд } n\text{- намуудын тоо,}$$

V_i -i дэх намын авсан саналын хувь,

S_i -i дэх намын авсан суудлын хувь.

Хувь тэнцэлгүй байдлын хоёр дахь индексийг (D) Жон Лусмор ба Виктор Ханди (Loosemore, Handy, 1971) нар санал болгосон. Тэдний санал болгосон индекс өөр санаан дээр үндэслэгдсэн. Энэ нь: авсан саналын тоо ба парламентад илүү төлөөлөлтэй намуудын суудал хоорондын зөрүүний нийлбэр парламентад дутуу төлөөлөлтэй намуудын холбогдох хэлбэлзэлийн дүнтэй ижил байна гэж үздэг. Эндээс тэд хэлбэлзлийн дүнгийн нийт модулийг хоёрт хуваадаг. Тэдний хувь тэнцэлгүй байдлын индекс дараах байдалтай байна.

$$D = \frac{1}{2} \sum_{i=1}^n |Vi - Si| \quad \text{Энд } n\text{- намуудын тоо}$$

Vi-*i* дэх намын авсан саналын хувь,
Si-*i* дэх намын авсан суудлын хувь.

Энэхүү индекс нь парламентад дутуу төлөөлөлтэй эсвэл илүү төлөөлөлтэй сонгогчдын хувийг тодорхойлдог. Их хэмжигдэхүүн нь хувь тэнцэлгүй байдал их байгааг илэрхийлдэг. Зарим тохиолдолд хувь тэнцэлгүй байдлын үзүүлэлтэд үзүүлэх жижиг намуудын нөлөөг багасгахын тулд (учир нь харьцуулалтанд том намуудын төлөөлөл дэх хувь тэнцэлгүй байдал илүү ач холбогдолтой) хувь тэнцэлгүй байдлын квадрат индексийг ашигладаг. Энэхүү томъёоны утга нь санал ба суудлын хувийн зөрүүг квадрат зэрэгт дэвшүүлж гарсан дүнг нэмж, түүнийг хоёрт хувааж, дараагаар нь гарсан дүнгээс квадратын язгуурыг гаргаж авдаг. (Moser, 1999, р.370). Тухайн хувь тэнцэлгүй байдлын индексийн томъёо нь дараах байдалтай байна.

$LSq = SqRt$ үз $\frac{1}{2} \sum (Vi - Si)^2$; Энд *LSq*- диспропорциональ / хувь тэнцэлгүй / байдлын индексийн квадрат

SqRt-квадратын язгуур,
Vi- сонгуульд *i* дэх намын авсан саналын хувь,
Si- парламент *i* дэх намын авсан суудлын хувь,

Намуудын системийн харьцуулсан судалгааны практикаас харахад эхний хувь тэнцэлгүй байдлын индекс жижиг намуудын хувьд үлэмж мэдрэгддэг бөгөөд бодит байдал дээр пропорциональ сонгуулийн системийн хувь тэнцэлт байдал илүү давамгайл байдаг. Хоёр дахь индекс нь сонгуульд оролцож байгаа намуудын тоонд илүү мэдрэгддэг, энд пропорциональ сонгуулийн системийн хувь тэнцэлт байдлыг дутуу үнэлэх талтай байдаг. Хоёр индексийн сул талуудаас зайлсхийхийн тулд Лейпхарт хувь тэнцэлгүй байдлын индексийг хоёр том намын парламентад авсан санал ба суудлын тооны хувь хоорондын зөрүүний дүнгийн дундаж хэмжээ болохыг санал болгосон. (Lijphart, 1984, р.163),

1984 оны есдүгээр сарын Канадын Палатын (общин) сонгуулийн үр дүн*

Намууд	Санал	хувь	Суудал	хувь
Консерватив дэвшилтэт нам	6276530	50,0	211	74,8
Либераль нам	3516173	28,0	40	14,2
Шинэ демократ нам	2358676	18,8	30	10,6
бусад	394596	3,1	1	0,4
Бүгд	12545973		282	

*Эх үүсвэр: Leonard, Natkiel, 1986. P.25.

Гурван улсад зориулан хувь тэнцэлгүй байдлын үзүүлэлтүүдийг харьцуулж үзье. Энд ХБНГУ-д холимог сонгуулийн систем, Финлянд улсад пропорциональ, Канадад-плюраль сонгуулийн систем үйлчилдэг, өөрөөр хэлбэл харьцангуй дийлэнхийн саналаар ХБНГУ болон Финляндын парламентуудын санал ба суудлын хуваарилалт хийгддэг. Ийм хуваарилалтыг Канадын Палатын (парламентын доод танхим) 1984 оны сонгуульд зориулан харуулья. (таблиц 8) Улс нэг бүрт зориулан санал ба суудлын хувийн хазайлтын модуль дүнг тооцье. Харин дараагаар нь диспропорциональ байдлын индексүүд *I*, *D*, *Лейпхарт* ба *LSq*

Герман улс: $I = \frac{1}{n} \sum_{i=1}^n |Vi - Si|$,

$I = |48.8 - 49.9| + |38.2 - 38.8| + |7.0 - 6.8| + |5.6 - 5.4| / 4 = 1.1 + 0.6 + 0.2 + 0.2 / 4 = 2.1 / 4 = 0.53$

$D = \frac{1}{2} \sum_{i=1}^n |Vi - Si|$,

$D = 2.1 + 0.2 + 0.2 + 0.1 / 2 = 2.6 / 2 = 1.3$ Лейпхартын индекс $= 1.7 / 2 = 0.85$

$Lsq = SqRt \quad 1.21 + 0.36 + 0.04 + 0.04 + 0.04 + 0.04 + 0.01 / 2 = 0.93$

Финлянд улс:

$I = |26.7 - 28.5| + |22.1 - 22.0| + |17.6 - 19.0| + |13.8 - 13.5| + |9.7 - 8.5| + |4.9 - 5.5| + |3.0 - 1.5| + |3.0 - 1.5| + |1.4 - 1.0| / 8 = 1.8 + 0.1 + 1.4 + 0.3 + 1.2 + 0.6 + 1.5 + 0.4 / 8 = 7.3 / 8 = 0.9$

$D = 7.3 + 0.1 / 2 = 7.4 / 2 = 3.7$

Лейпхартын индекс $= 1.8 + 0.1 / 2 = 1.9 / 2 = 0.95$

$Lsq = SqRt \quad 3.24 + 0.01 + 1.96 + 0.09 + 1.44 + 0.36 + 2.25 + 0.16 + 0.01 \times 2 = 2.2$

Канад улс: $I = |50.0 - 74.8| + |28.0 + 14.2| + |18.8 - 10.6| + |3.1 - 0.4| / 4 =$

$24.8 + 13.8 + 8.2 + 2.7 / 4 = 49.5 / 4 = 12.4$

$D = 49.5 / 2 = 24.8$

Лейпхартын индекс $= 38.6 / 2 = 19.3$

$Lsq = SqRt \quad 615.04 + 190.44 + 67.24 + 7.29 / 2 = 21$

Эдгээр хувь тэнцэлгүй байдлын индексүүдийн үзүүлэлтүүдийн харьцуулалт нь холимог систем болон пропорционал системүүдэд зарчмын хувьд сонголтын төлөөлөл нь нэг нь нөгөөгөөсөө ялимгүй ялгаатай байгааг харуулж байна. Герман улсад хувь тэнцэлгүй байдлын I, D, Лейпхартын ба Lsq индексүүд 0,53; 1.3; 0.85 ба 0.93; Финлянд улсад 0.9; 3.7; 0.95 ба 2.2; Канадын плюраль системийн хувьд хувь тэнцэлгүй байдлын үзүүлэлтүүд өндөр байна. 12.4; 24.8; 19.3 ба 21. Ерөнхийдөө энд сонгогчдын 24.8% парламентад төлөөллөө авч чадаагүй, өөрөөр хэлбэл тэнд өөрсдийн төлөөлөгчгүй байна. Канадын консерватив дэвшилтэт нам сонгогчдын 50,0% саналыг авч чадах бараг 75% суудал авсан, харин либераль нам сонгогчдын саналаасаа хоёр дахин бага суудлыг авсан байна. Плюраль сонголттой холбоотой иймэрхүү нөхцөл байдлыг сайн мэддэг боловч хувь тэнцэлгүй байдлын индекс нь энэхүү системийн сул талыг ил тод харуулаад зогсохгүй мөн намын систем ба парламентаризмын бусад нөхцлүүдийг судлахад ашиглаж болдог.

Намуудын системийг тодорхойлдог нөхцөл байдлын судалгаа

Намуудын системийн тоон үзүүлэлтүүдийг тодорхойлдог хүчин зүйлсийг судлахын тулд харьцуулсан улс төр судлалд дараах онолын загваруудыг ашигладаг. **Нэгдүгээрт**, тодорхой судлаачид “Дювержийн хууль” гэж нэрлэгдсэн зүй тогтол дээр үндэслэдэг: “нэг үе шаттай энгийн олонхын систем нь хоёр намын системд таатай байдаг” (нэг мандаттай тойрогт харьцангуй олонхын дүрмээр) (Duverger, 1954, p.217) Энд үндсэн хүчин зүйл нь намын системийн шинж болж өгдөг, харин энэ хандлагын логик нь сонгогчдын сонгуулийн системийн хувьд боломжит ялагчийн төлөө л гол төлөв саналаа өгдөг (гуравдагч намын төлөө бус), харин намын лидерүүд нь эвсэхийн төлөө, эсвэл саналын дийлэнхийг байлдан дагуулахын тулд өөрийн намын боломжийг бэхжүүлэх болно. Энэхүү загвар нь намуудын системийг судлахад институционал гэж нэрлэгдэх болсон хандлагын суурь үндэс нь болдог. Энд нөхцлүүд нь зөвхөн сонгуулийн систем байгаад зогсохгүй мөн түүнчлэн бусад институционал хүчин зүйлс байна. Улс төрийн дэглэм, төрийн хэлбэр, намуудын системийн эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээ гэх мэт. **Хоёрдугаарт**, Липсет ба Рокканын 1967 онд (Lipset, Rokkan) санал болгосон “европын намуудын системийн тогтворжилт” –ын загварыг зарим судлаачид намуудын системүүдийг

судлахдаа ашигладаг. Энэ загвараар бол европын улс орнуудын намуудын системд өнгөрсөн зууны 20-иод оны үед тогтсон улс төрийн өрсөлдөөнт нийгмийн тодорхой бүтцүүд үлэмж нөлөө үзүүлдэг байна. Европт намуудын систем нь хүн амын төрөл бүрийн бүлгүүдийн хоорондын харилцаанд онцлог байдаг нийгмийн эквилибриумыг илэрхийлдэг. Тухайн загвар нь намуудын систем болон юуны өмнө нийгмийн ялгаралтай холбоотой бүхий л хүчин зүйлсийг тодорхойлдог төрөл бүрийн нийгмийн шалтгаануудыг эрэлхийлэх үндэслэл болж өгсөн байна. **Гуравдугаарт** зарим судлаачид институциональ ба нийгмийн загваруудын өгөгдлүүдийг онолын нэг бүтцэд нэгтгэхийг оролдсон. Энд намуудын системийг судлах зорилго нь институциональ ба нийгмийн гэсэн хамааралгүй хувьсагчдын сонголтыг тодорхойлдог. Тухайлбал, Октавио Нето ба Гари Кокс нар дараах таамаглалуудыг тодотгон өгч түүндээ тохируулан хамааралгүй хувьсагчдын системийг байгуулдаг. (Neto, Cox, 1997, p.149-174)

- (1) Электораль намуудын үр ашигтай тоонд нөлөө үзүүлдэг нийгмийн ялгарал ба сонгуулийн системийн хооронд уялдаа холбоо оршдог.
- (2) Парламентын сонгууль ба ерөнхийлөгчийн систем дэх ерөнхийлөгчийн сонгуулийн хооронд уялдаа холбоо оршдог.
- (3) Парламентын намуудын үр ашигтай тоо ба электораль намуудын үр ашигтай тоон хооронд уялдаа холбоо оршдог.
- (4) Парламентын намуудын үр ашигтай тоо ба үндэстний нэрийн жагсаалтаар гишүүдийг сонгох сонголтын ач холбогдол хооронд уялдаа холбоо оршдог.

Тухайн таамаглалуудыг судлахын тулд дараах хамааралгүй хувьсагчдыг санал болгосон байна.

1. Сонгуулийн тойргийн ач холбогдол

Сонгуулийн тойргийн ач холбогдлыг ихэнхдээ сонгуулийн тойргуудын дундаж хэмжигдэхүүний үзүүлэлтээр дамжуулан тодорхойлдог. Тойргийн хэмжигдэхүүн гэдэгт нэг тойрогт байгаа мандатын тоог ойлгодог. Тухайлбал, хэрэв Финляндад парламентын 200 гишүүнийг нэг мандаттай 15 тойргоос сонгодог бол мандатын тоо 1-ээс 27 хүртэл хэлбэлзэж байдаг. Энд сонгуулийн тойргийн дундаж хэмжээ 13,3 байна. Тойргууд хоорондын мандатын зөрүү зарим тохиолдолд хэдэн арван нэгж хүрч байгаа учраас электораль тойргийн ач холбогдлыг илүү нарийн тодорхойлохын тулд дундаж хэмжигдэхүүнийг биш харин медианы үзүүлэлтүүдийг ашигладаг. Финлянд улсын хувьд авч үзвэл тухайн үзүүлэлт нь 17 болж байна. Учир нь депутатуудын 50%-ийг 17 мандаттай тойргуудаас сонгодог, үлдсэн 50%-ийг 17-оос доош мандаттай тойргуудаас сонгодог. Бидний авч үзэж буй судалгаанд зохиогчид медианы үзүүлэлтүүдийг ашигласан ба электораль тойргийн ач холбогдлыг хууль тогтоох байгууллагын сонгуулийн тойргийн медианы хэмжигдэхүүний аравтын логарифм гэж тодорхойлдог. (LML-the logarithm of the median legislator's district's magnitude)

$LML = \lg M$, энд M-электораль тойргийн медианы хэмжигдэхүүн

2. Нийт үндэстний нэрийн жагсаалтаар сонгодог сонгуулийн ач холбогдол

Зарим улс орнуудад ердийн сонгуулийн тойргуудын хамт нийт үндэстний тойргууд байдаг ба улмаар нийт үндэстний депутатуудад нэр дэвшигчдийн жагсаалт байна (таблиц 9). Ийм нөхцөл байдал нь намуудын системийн шинж, үндэстний хэмжээн дэх намуудын хамтын харилцаанд ул мөрөө үлдээдэг ба намууд орон нутгийн болон нийт үндэстний түвшини хоёрдмол

тактикийг ашиглахад хүрдэг. Жижиг намууд нийт үндэстний тойргуудад том намуудтай өрсөлдөж чадахгүй болохоор энэ байдал нь намууд аяндаа томрох үйл явцыг түргэтгэдэг. Мөн нийт үндэстний тойргуудад ялалт байгуулах нь намын нэр хүндийг өсгөдөг. *Таблиц 9.*

Нийт үндэстний тойргуудын санал хураалтын үр дүнгээрх парламент дахь (доод танхимууд) суудал хуваарилалт

Улс	Сонгуулийн огноо	Гишүүдийн тоо	Нийт үндэстний сонгуулийн тойргуудаас сонгогдсон депутатууд	
			тоо	хувь
Австри	1986	186	21	11,4
Бельги	1985	212	85	40,0
Венесуэл	1983	200	18	9,0
Герман	1983	498	248	49,8
Грек	1985	232	56	24,1
Исланд	1983	60	11	18,3
Итали	1983	630	72	11,4
ОХУ	1995	450	225	50,0
Уругвай	1989	99	27	27,2
Чех	1990	101	5	5,0

Электоральный [лат.elector-сонгож байгаа, сонгогч]-сонгуулийн Нийт үндэстний сонгуулийн тойргоор гишүүдийг сонгох сонгуулийн ач холбогдлыг UPPER (upper-tier variable) индексээр бүртгэдэг. Үүнийг нийт үндэстний тойргуудаас сонгогдож буй депутатуудын эзлэх хувь гэж тооцоолдог.

3. Ерөнхийлөгчийн ба парламентын сонгууль ойртох

Ерөнхийлөгчийн ба хагас ерөнхийлөгчийн тогтолцоотой бүгд найрамдах улсуудад намууд зөвхөн парламентын гишүүдийн сонгуульд сонгогчдын саналын төлөө өрсөлдөөнд оролцоод зогсохгүй, мөн түүнчлэн ерөнхийлөгчийн сонгуульд оролцдог. Мэдээжийн хэрэг энд сонгуулийн тэмцлийн стратеги ба тактик ихээхэн ялгаатай байдаг. Үүний чацуу ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулах эсвэл ялагдах хүлээх нь парламентын сонгуульд мөн нөлөөлдөг. Энэ нь ерөнхийлөгчийн ба парламентын сонгуулийн цаг хугацаа нийлж байгаа үед онцгой мэдрэгдэнэ. Намын системийг судлахад тухайн хүчин зүйлийг тооцох хэрэгтэй. Нето болон Коксын санал болгосон ерөнхийлөгчийн ба парламентын сонгуулиудын ойр дөтийн индекс нь (PROXIMITY)-ийг дараах томъёогоор тооцоологдоно:

$$PROXIMITY=2\left|\frac{(L_j-P_{j-1})}{(P_{j+1}-P_{j-1})} - \frac{1}{2}\right|,$$

Энд: L_j - парламентын сонгуулийн тов (огноо),

P_{j-1} – Ерөнхийлөгчийн өмнөх сонгуулийн огноо,

P_{j+1} – Ерөнхийлөгчийн дараагийн сонгуулийн огноо.

Энэ томъёо нь ерөнхийлөгчийн засаглалын хугацаанд ($P_{j+1}-P_{j-1}$) харьцуулсан өмнөх ерөнхийлөгчийн сонгууль ба парламентын сонгууль хоорондын (L_j-P_{j-1}) өнгөрсөн хугацааг илэрхийлдэг. Энэ өнгөрсөн хугацаанаас 1/2-г хасаад улмаар модуль хэмжигдэхүүнийг тооцоолсноор ерөнхийлөгчийн сонгуулийн хугацааны дунджаас парламентын сонгууль хэр хол байгааг харуулж буй үр дүнг олж авна. Энэхүү томъёо нь дараах логик утгыг илэрхийлнэ. Ерөнхийлөгчийн засаглалын

хугацааны дунд үед явагдсан парламентын сонгууль нь ерөнхийлөгчийн сонгуулиас арай хол болсон гэж тооцогдоно.

Жишээ нь: Тухайн индексийн үзүүлэлтийг Финлянд улсад зориулан тооцож үзье. Хэрэв Финляндад парламентын сонгууль 1983 оны гуравдугаар сард болсон, ерөнхийлөгчийн сонгууль 1982 оны нэгдүгээр сард болж өнгөрсөн, дараагийн ерөнхийлөгчийнх 1988 оны нэгдүгээр сард болох бол ерөнхийлөгчийн хугацаа 6 жил байна, тэгвэл

$$\text{PROXIMITY} = 2 \left| \frac{3.83 - 1.82}{1.88 - 1.82} - \frac{1}{2} \right| = 2 \left| 14/72 - \frac{1}{2} \right| = 0.61$$

Хэрэв тэг үзүүлэлт нь ерөнхийлөгчийн бус системүүд дэх парламентын сонгуулиудын бүрэн тусгаарлагсдын байлыг илэрхийлж байгаа бол **нэг** байх нь хугацаа бүрэн давхцаж байгааг харуулж байгаа бол энд **0,61** гарсан нь парламентын сонгууль ерөнхийлөгчийн сонгуулийн дундаас 2/3 байгааг илэрхийлж байна. Зохиогчид нь олонлогийн регрессийг ашиглан төрөл бүрийн институциональ хүчин зүйлсээс парламентын намуудын үр ашигтай тооны хамаарлыг харуулах зорилгыг тавьсан байна. (ENPS):

$$\text{ENPS} = \alpha + \text{ENPV}(\beta_0 + \beta_1 \text{LML} + \beta_2 \text{UPPER}) + E,$$

Энд: α - тогтмол итгэлцүүр,

$\beta_0, \beta_1, \beta_2$ - эрэлхийлж буй хамаарлуудыг тодорхойлж байгаа регрессийн итгэлцүүрүүд;

E- хэмжилтийн стандарт алдаа.

Судалгааны үр дүнг таблиц 10-рт харуулсан байна. Таблиц 10.

Парламентын намуудын үр ашигтай тооны детерминантууд*

Хамааралтай хувьсагч: ENPS Хамааралгүй хувьсагчид:	Үнэлгээний итгэлцүүрүүд	Стандарт алдаанууд
CONSTANT	0.582	0.135
ENPV	0.507	0.048
ENPV*LML	0.080	0.012
ENPV*UPPER	0.372	0.111
Нарийвчилсан R ² =N	0.921	
	0.54	

*Эх сурвалж: Neto, Cox, 1977. P.163.

Дээрх таблицаас үзэхэд өгөгдлүүд нь парламентын намуудын үр ашигтай тоонд вариацийн үлэмж хувь (93%) байгааг ENPV ба сонгуулийн системийн хоёр хүчний үзүүлэлтүүд болох LML ба UPPER-ийн ENPV-тэй харилцан үйлчилж байгааг харуулж байна. Мөн түүнчлэн хэрэв сонгуулийн систем нь нэг мандаттай тойргууд (LML=0) дээр байгуулагдсан ба нийт үндэсний тойрог байхгүй (UPPER=0) бол тэрбээр маш их хүчтэй байна гэдэг нь нотлогдсон ба өөрөөр хэлбэл парламентын намуудын тоо багасна. Сонгуулийн тойргийн ач холбогдлын үзүүлэлтүүд болох LML ба нийт үндэсний тойргийн сонгуулийн үзүүлэлтүүд UPPER тооцоологдон гарч ирснээр систем нь илүү либерал болж парламентын намуудын тоо нэг их буурахгүй (эсвэл бараг өөрчлөгдөхгүй). Ерөнхийлөгчийн ба парламентын сонгуулийн хугацаа ойр байх нь парламентуудын намуудын тоонд ихээхэн нөлөө үзүүлдэг. Тухайн судалгаанд институциональ хүчин зүйлүүд ба нийгмийн ялгаварт байдлын хооронд хамаарал байгааг; намуудын системийг тодорхойлоход институциональ үзүүлэлтүүд нь зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг гэдгийг тус тус тодруулж өгсөн байна.